



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 7/02

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Макс Хотелс ХХК-ийн “Холидей Инн” зочид буудлын 19/458, Оюуны аав ХХК-ын “Агора” зочид буудлын 19/427, Улаанбаатар зочид буудал ХХК-ийн “Улаанбаатар” зочид буудлын 20/14, Улаанбаатар зочид буудал ХХК-ийн “Улаанбаатар 2” зочид буудлын 20/15, Сонжин групп ХХК-ийн “Сонжин гранд” зочид буудлын 19/170, Сайхан хүлэг ХХК-ийн “Хулэг” дэн буудлын 20/461, Мандах хөлөг ХХК-ын “Номуун” зочид буудлын 19/467, Түшигт агь ХХК -ын “ТНТ” зочид буудлын 19/399, Гинза ХХК-ын “Эн жи” дэн буудлын 20/342, Есөн гарыд ХХК-ийн “Онон” дэн буудлын 20/27, Жава инн ХХК-ийн “Жой” дэн буудлын 20/08 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

1150500005

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Р.Батням/-т үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.
6. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 01 сарын
28-ны өдрийн A/02 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 2936 1118203502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Макс Хотелс ХХК	5445914	Холидэй Инн	ЧД-ийн, 5-р хороо, Самбууугийн гудамж 24
2	Оюуны аав ХХК	5299691	Агора	БЗД-ийн, 16-р хороо, 16-р хороолол, 40-1
3	Улаанбаатар зочид буудал ХХК	2026864	Улаанбаатар	СБД-ийн, 8-р хороо, Бага тойруу 14200
4	Улаанбаатар зочид буудал ХХК	2026864	Улаанбаатар 2	НД-ийн, 6-р хороо, Тэрэлж гудамж 48-7 тоот
5	Сонжин групп ХХК	5051479	Сонжин гранд	БЗД-ийн, 13-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 63
6	Сайхан хүлэг ХХК	5276527	Хүлэг	БЗД-ийн, 25-р хороо, 13-р хороолол, Манлайбаатар Дамдин сүрэнгийн гудамж 34/1 тоот
7	Гинза ХХК	2341832	Эн Жи	БЗД-ийн, 2-р хороо, Б.Доржийн гудамж 2А байр
8	Мандах хөлөг ХХК	50956387	Нарлаг	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатын гудамж 6н-15 тоот
9	Түшигт агь ХХК	6420109	ТНТ	БГД-ийн, 20-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 190

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 01 сарын
25-ны өдрийн A/02 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 2926 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Есөн гарьд ХХК	2099667	Онон	БЗД-ийн, 5-р хороо, Өлгийн 31-48 тоот
2	Межиквотер ХХК	5363381	Найзууд	БЗД-ийн, 19-р хороо, Да хүрээ 41А тоот
3	Жава иин ХХК	6500811	Жой	БЗД-ийн, 18-р хороо, 13-р хороолол, 38-214 тоот
4	Норлин очир ХХК	5147964	Орд	БГД-ийн, 5-р хороо, 10-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР